

**БАТЛАВ:**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**

**Ш. РАДНААСЭД**

**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАРЫН  
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙН УЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл шаардлага.**

**1.1. Хууль зүйн үндэслэл.**

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 63 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого (2015-2030)”-д Эрчим хүчний салбар нь улс орны аюулгүй байдал, эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах, түрүүлж хөгжүүлэх шаардлагатай эдийн засгийн суурь салбар мөн гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 4.2.7-д “Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн эрчим хүч, инженерийн дэд бүтцийг хөгжүүлнэ” гэж тусгасан.

**1.2. Практик шаардлага.**

Эрчим хүчний төрийн өмчит компани нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ төрийн эрх бүхий байгууллагаас тогтоосон үнэ тарифаар борлуулдаг бөгөөд энэ нь үйлдвэрлэх, түгээх, дамжуулах, өргөөс бага байдаг тул төвөөс алслагдмал аймаг, сумыг цахилгаан эрчим хүчээр хангадаг цөөн тооны компанийд үнийн зөрүүг татаас хэлбэрээр улсын төсвөөс олгодог бөгөөд эдгээр компаниудад дараах хүндрэлтэй асуудал тулгарч байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.15-д “төрөөс олгож байгаа төсвийн санхүүжилт, татаас, урамшууллыг нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулах үйл ажиллагаанд нэгэн адил хамруулна” гэж заасан нь тухайн хуулийн этгээдийн алдагдлыг нэмэгдүүлж, мөн хэмжээгээр хөрөнгө оруулалт санхүүжилт буурах нөхцлийг бүрдүүлж байна.

Эрчим хүчний төрийн өмчит компанийн усан цахилгаан станцын барилга, усны барилга байгууламж зэрэгт зарим орон нутгийн татварын байцаагч нар үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулж байна. Энэ нь захиргааны хэргийн шүүхэд маргаан үүсгэж, улмаар анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхээр хянан хэлэлцэгдэж байна. Гэтэл зарим орон нутгийн татварын байцаагч нар Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгө, 7.1.3-т нийтийн эзэмшлийн барилга байгууламж гэж заасныг үндэслэн үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулдаггүй байна.

**Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.2 дахь заалтын дагуу хуульд нэмэлт оруулах хуулийн төсөл хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төсөлд дээр дурдсан үндэслэл шаардлагад тулгуурлан зохицуулах дараах асуудлыг тусгана.

Үүнд: Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт эрчим хүчний төрийн өмчит компанийн усан цахилгаан станцын барилга, усны барилга байгууламж гэсэн заалтыг нэмэлтээр оруулна.

**Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээний санал.**

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар төрийн өмчит компани, төрийн өмчит үйлдвэрийн газарт татварын харилцаанд үүсч байгаа хүндрэлтэй асуудал шийдвэрлэгдэнэ, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, уламжлалт эрчим хүчний байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад дэмжлэг болно.

Улс орны эдийн засгийн өсөлт, тогтвортой хөжил, эрчим хүчний аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангана.

**Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах**

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна.

--- оОо ---